

БҮТЭЭЛИЙН ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны ____-р сарын ____-ний өдөр

№ БЭШГ

Улаанбаатар хот

Гэрээний талууд:

Нэг талаас: “Монгол Контент” ХХК / цаашид “Монгол Контент” гэх/, түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал

Нөгөө талаас: тоот регистрийн дугаартай иргэн овогтой /цаашид “Эрх эзэмшигч” гэх/ нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ Монгол Улсын Иргэний хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасныг үндэслэн дараах нөхцлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг /цаашид “Гэрээ” гэх/ байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь “Эрх эзэмшигч” нь өөрийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалагдсан дуу авиа болон дуу авиа бүхий дүрст бүтээл /цаашид Бүтээл гэх/ тэдгээрийг багцласан цомгийг /цаашид Цомог гэх/ түгээх, худалдаалах, ашиглах онцгой эрхийг “Монгол Контент”-д шилжүүлэх, “Монгол Контент” нь “Эрх эзэмшигч”-ийн бүтээлийг өөрийн болон гуравдагч талын үйлчилгээнд ашиглах, түгээх, худалдаалах түүнээс үүдэн гарах эрх зүйн болон санхүүгийн бүх харилцааг зохицуулна.
- 1.2. “Эрх эзэмшигч” нь энэхүү гэрээгээр эрх шилжүүлсэн цомог, бүтээлийн зохиогчийн эрхэд хамаарах эрхийн эзэмшигч эсвэл тус эрхийг шилжүүлэн авсан этгээд байна.
- 1.3. Энэхүү гэрээний хавсралтууд нь тус гэрээний салшгүй хэсэг болно.

Хоёр. Гэрээний үйлчлэх хугацаа

- 2.1. Гэрээ нь “Талууд”-ын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 2021 оны ____-р сарын ____-ний өдрөөс 2026 оны ____-р сарын ____-ний өдөр хүртэл 5 /таван/ жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 2.2. Гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө аль нэг тал нь гэрээг цуцлах, дуусгавар болгох санал бичгээр ирүүлээгүй тохиолдолд гэрээг дахин 5 /таван/ жилийн хугацаатай ижил нөхцлөөр сунгасанд тооцно.
- 2.3. Энэхүү гэрээ дараах үндэслэлээр дуусгавар болно.
 - 2.3.1. Гэрээний хугацаа дууссан;
 - 2.3.2. Талууд харилцан тохиролцож шийдвэрлэсэн;
 - 2.3.3. Талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас хамтын үйл ажиллагааны зорилго биелэгдэх боломжгүй болсон;

Гурав. Шилжүүлж буй эрх, бүтээл, түүний ашиглалт

- 3.1. “Монгол Контент”- нь гэрээний 1.1 –н дагуу шилжүүлж авсан эрхийн хүрээнд “Эрх эзэмшигч”-ийн бүтээлийг дараах байдлаар өөрийн болон гуравдагч талын үйл ажиллагаанд ашиглана.
 - 3.1.1. Үүрэн холбооны операторуудын гар утасны дуудлаганд /ringbacktone/ бүтээлийг ашиглуулах;
 - 3.1.2. Онлайн сүлжээ ашиглан дуу, хөгжмийн болон дуу авиа бүхий дүрст бүтээлийг хэрэглэгчдэд сонгох үйлчилгээнд /music stream/ ашиглуулах;
 - 3.1.3. Онлайн сүлжээ ашиглан бүтээлийг цахим хэлбэрээр борлуулах,
- 3.2. “Монгол Контент” нь 3.1 –д заасан үйлчилгээнүүдэд бүтээлийг ашиглуулахдаа “Эрх эзэмшигч”-ийн нэр, гэрэл зураг, дүр төрх, намтар, бүтээлийн нэр, түүнтэй холбоотой зураг болон бусад мэдээллийг ашиглуулах эрхтэй байна.
- 3.3. “Эрх эзэмшигч”-ийн цомог, бүтээлийг гуравдагч хувь хүн, хуулийн этгээд ижил төрлийн үйлчилгээнд албан ёсны эрхгүй зөвшөөрөлгүй ашигласан, худалдсан тохиолдолд Монгол Контент нь тухайн этгээдэд энэ тухай мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль, хяналтын байгууллагад хүсэлт, гомдол гаргаж, энэ үйлдлыг таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагаа явуулах эрхийг Эрх эзэмшигч нь Монгол Контент -д олгоно.
- 3.4. Гэрээний хүчинтэй хугацаа дууссанаар гэрээний 3.1-д заасан эрх “Эрх эзэмшигч”-д шилжинэ.
- 3.5. Эрх шилжүүлж буй бүтээл:
 - 3.5.1. “Эрх эзэмшигч” нь гэрээний Хавсралт №1–т заасан бүтээлийг энэхүү гэрээний 3.1-д заасан нөхцөлийн дагуу ашиглуулах, түгээх, худалдаалах онцгой эрхийг “Монгол Контент”-д олгоно.
 - 3.5.2. “Эрх эзэмшигч”-ийн энэхүү гэрээний дагуу эрх шилжүүлэн өгч буй бүтээл нь Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчилгүй байна.

Монгол Контент: _____

Эрх эзэмшигч: _____

- 3.5.3. “Эрх эзэмшигч” нь гэрээний хүчинтэй хугацаанд шинээр туурвисан бүтээлийн бүтээл ашиглах эрхийг энэхүү гэрээний нөхцөлөөр “Монгол Контент”-д шилжүүлэх бөгөөд тухай бүр “Монгол Контент” –с гаргасан онлайн системд байршуулна.
- 3.6. Эрх шилжүүлж буй бүтээлийн ашиглалт:
- 3.6.1. “Монгол Контент” нь бүтээлийг гэрээнд заасан хугацаанд 3.1-д заасан эрхийн хүрээнд дотоодын болон олон улсын үйлчилгээнүүдэд тухайн байгууллагатай байгуулсан гэрээ, үйлчилгээний нөхцөл, үнэ тариф, журмын дагуу ашиглуулна.

Дөрөв. Бүтээлийн үнэ тариф, Орлого хуваарилалт, Төлбөр тооцоо

- 4.1. “Эрх эзэмшигч” –н бүтээлийг ашиглах, худалдаалах үнийг тухайн бүтээлийг ашиглаж байгаа байгууллагын мөрдөж буй үнэ тарифийн дагуу тогтоох бөгөөд “Эрх эзэмшигч” нь цахим хэлбэрээр цомог худалдаалах үнийг тогтоож болно.
- 4.2. Бүтээл ашиглаж буй үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тодорхой хугацаатайгаар урамшуулал зарлаж, контентийн үнэ тарифыг өөрчилж болох ба энэ тохиолдолд бууруулсан үнээс орлого хуваарилна.
- 4.3. “Монгол Контент” нь бүтээлийн орлогоос (НӨАТ-гүй багтаагүй дүнгээс) доорхи байдлаар сар бүр “Эрх эзэмшигч”-д орлого хуваарилна.
- 4.3.1. Гэрээний 3.1.1 д заасан үйлчилгээнд ашигласан **бүтээлийн нийт орлогын 30 хувийг**;
- 4.3.2. Гэрээний 3.1.2, 3.1.3 болон бусад үйлчилгээнд ашигласан бүтээлийн **бичлэгийн эрхэд ноогдох орлогын 70 хувийг**;
- 4.3.3. Бичлэгийн эрхэд ноогдох орлого гэдэг нь тухайн бүтээлийг ашигласаж олсон орлогоос бүтээл ашиглагч байгууллага өөрийн шимтгэл болон 4.4 –т заагдсан зохиогчийн эрхийн төлбөрийг хассан орлогыг хэлнэ.
- 4.4. “Монгол Контент” нь энэхүү гэрээний дагуу ашиглагдаж байгаа бүтээлийн зохиогчийн эрх эзэмшигч нарт /хөгжмийн зохиолч, яруу найрагч/ ноогдох **зохиогчийн эрхийн төлбөрийг** хамтын удирдлагын байгууллагатай /Монголын Зохиолч, Хөгжмийн Зохиолч, Нийтлэгчдийн Нийгэмлэг/ байгуулсан гэрээний дагуу шилжүүлнэ.
- 4.5. Хэрэв эрх эзэмшигч нь тухайн бүтээлийн зохиогчийн эрхийг давхар эзэмшдэг бол “Монгол Контент” – той Зохиогчийн эрхийн гэрээ байгуулан зохиогчийн эрхийн төлбөрийг авч болно.
- 4.6. Энэхүү гэрээний дагуу “Эрх эзэмшигч”-н бүтээлийг хоёр болон түүнээс дээш уран бүтээлч хамтран дуулсан бөгөөд тухайн бүтээлээс олсон орлогыг эдгээр уран бүтээлч нартай хуваах шаардлагатай тохиолдолд “Эрх эзэмшигч” нь энэ талаар хүсэлтээ бичгээр ирүүлнэ.
- 4.7. Бүтээл ашигласны төлбөр, тооцоог сараар гаргах бөгөөд “Эрх эзэмшигч” нь сар бүрийн 10-наас хойш Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасны дагуу, НӨАТ-ын хуулийн 4.1.14 заалт дахь шаардлага хангасан төлбөрийн баримтыг татварын нэгдсэн системд илгээж, хэвлэж өгөх эсвэл ebarimt@mobicom.mn хаяг руу илгээнэ.
- 4.8. “Монгол контент” нь 4.6 –д заасан төлбөрийн баримтыг хүлээн авсанаас хойш ажлын 5 өдрийн дотор “Эрх эзэмшигч”-ийн банкны тоот дансанд “Эрх эзэмшигч” –д хуваарилагдах орлогоос ХХОАТ-ын 26.1-т заасны дагуу эрхийн шимтгэлийн орлогын 10 хувийн татварыг хасч шилжүүлнэ.
- 4.9. Хэрэв “Эрх эзэмшигч”-д ноогдох орлогын дүн 100,000 төгрөгөөс доош байвал дараагийн саруудын тооцоотой нийлүүлэн шилжүүлнэ.

Тав. Талуудын эрх, үүрэг

5.1. “Эрх эзэмшигч”-ийн эрх, үүрэг:

- 5.1.1. “Эрх эзэмшигч” нь бүтээлийн ашиглалт, түгээлтийн дэлгэрэнгүй тайлантай танилцах эрхтэй.
- 5.1.2. “Эрх эзэмшигч” нь энэхүү гэрээний дагуу зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчилгүй бүтээлийн эрхийг шилжүүлэх үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд “Эрх эзэмшигч” нь тухайн бүтээлийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчилгүйг баталгаажуулсан зохиогчийн эрхийн гэрчилгээ, гэрээ, холбогдох баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Монгол Контент-д ирүүлж, гэрээнд хавсаргах үүрэгтэй.
- 5.1.3. “Эрх эзэмшигч” нь эрх шилжүүлж буй бүтээлийг биет (CD, DVD) болон цахим хэлбэрээр дуу авиа, дүрс бичлэг болон техникийн шаардлага хангасан, бичлэгийн өндөр чанартай дуу авиа бол WAV, дуу авиа бүхий дүрт бүтээл бол Full HD болон бусад боломжит өндөр чанартайгаар холбогдох мэдээллийн хамт “Монгол Контент” –с гаргаж өгсөн онлайн системд оруулан хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.1.4. “Эрх эзэмшигч” нь энэхүү гэрээний 3.1-д заасан эрхийг гэрээний хугацаанд өөр хуулийн этгээд, иргэнд ашиглуулах, худалдах, шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

- 5.1.5. “Эрх эзэмшигч” нь “Монгол Контент” болон түүний хамтран ажиллаж байгаа гуравдагч байгууллагуудтай ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдтэй давуу тал олгож гэрээ байгуулахгүй байх үүрэгтэй.
- 5.1.6. Эрх эзэмшигч” нь энэхүү гэрээгээр эрх шилжүүлсэн бүтээлийн борлуулалт, түгээлтийг дэмжих үүднээс үйлчилгээ үзүүлэгч байгууллагын сурталчилгаа мэдээллийг өөрийн олон нийтийн сүлжээ болон боломжит сурталчилгааны сувгаар сурталчилах үүрэгтэй.

5.2. “Монгол Контент”-ийн эрх, үүрэг:

- 5.2.1. “Монгол Контент” нь гэрээний хүчинтэй хугацаанд эрхийг нь шилжүүлэн авсан бүтээлийг 3.1-д заасан эрхийн дагуу ашиглах, түгээх, худалдаалахтай холбоотой бүх асуудлаар гуравдагч талуудтай гэрээ, хэлцэл хийх эрхтэй байна.
- 5.2.2. “Монгол Контент” нь бүтээлийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевиз, радио, интернэтийн орчинд сурталчлах тохиолдолд “Эрх эзэмшигч”-ийн болон бүтээлийн гэрэл зураг, дүрс бичлэг зэргийг ашиглах, “Эрх эзэмшигч”-ийг реклам сурталчилгаанд тоглуулах эрхтэй байна.
- 5.2.3. “Монгол Контент” нь нийлүүлж буй үйлчилгээний нөхцөлөөс шалтгаалан бүтээлийг хувиргах, хэсэгчлэн хуваахдаа бүтээлийн утга, агуулгыг өөрчлөх, засварлах, гажуудуулахгүй байх үүрэгтэй.
- 5.2.4. Монгол Контент” нь “Эрх эзэмшигч”-ийг бүтээлийн ашиглалт, түгээлтийг хянах боломжоор хангах үүрэгтэй.
- 5.2.5. “Эрх эзэмшигч” нь 5.1.2 -т заасан мэдээллийг бүрэн ирүүлээгүй тохиолдолд бүтээл ашигласны төлбөрийг шилжүүлэхгүй байх эрхтэй.

Зургаа. Нууц хадгалах

- 6.1. Талууд энэхүү гэрээний заалтуудтай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамааралтай аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон аливаа бусад хэлбэрээр задруулахгүй байх үүрэгтэй энэхүү үүргээ зөрчсөний улмаас нөгөө талдаа учирсан хохирлыг бүрэн хариуцна.

Долоо. Талуудын хариуцлага

- 7.1. “Эрх эзэмшигч”-ийн энэхүү гэрээний дагуу эрх шилжүүлсэн бүтээлүүд зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн аливаа зөрчилгүй байхыг “Эрх эзэмшигч” бүрэн хариуцна. Хэрэв үүнтэй холбогдсон маргаан, зөрчил гарвал түүний хариуцлага, төлбөр, зардал хохирлыг “Эрх эзэмшигч” бүрэн хариуцна.
- 7.2. Энэхүү гэрээний 4.4 т заасны дагуу “Эрх эзэмшигч”-ийн хоёр болон түүнээс дээш уран бүтээлч хамтран дуулсан бүтээлийн орлогыг гуравдагч эрх эзэмшигчтэй хуваагаагүйтэй холбоотой гарах хариуцлага, төлбөрийг “Эрх эзэмшигч” бүрэн хариуцна.
- 7.3. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй болон зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээ, мөн Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээх бөгөөд нөгөө талд учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 7.4. Энэхүү гэрээ нь 2.3.3 –т заасан үндэслэлээр хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд гэм буруутай тал гэрээг дуусгавар болгосноос нөгөө талд учирсан хохиролыг бүрэн барагдуулах үүрэг хүлээнэ.

Найм. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах

- 8.1. Гэрээний хүчинтэй хугацаанд аль ч тал нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэж болох ба саналыг хүлээн авсан тал 14 хоногийн дотор нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаар өөрийн саналыг хариу мэдэгдэнэ.
- 8.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.
- 8.3. Гэрээний 2.1 –д заасан хугацаанд гэрээний аль нэг тал нь дангаар гэрээг цуцлах эрхгүй.
- 8.4. Аль нэг тал гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах саналтай бол энэ тухайгаа нөгөө талд 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Ес. Маргаан шийдвэрлэх

- 9.1. Талууд үйл ажиллагаандаа шударга ёсыг эрхэмлэн харилцан ашигтай хамтран ажиллах зарчмыг удирдлага болгон энэ гэрээтэй холбогдон үүсэх аливаа маргаан, санал зөрөлдөөнийг аль болох зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг хичээх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арав. Бусад зүйл

- 10.1 Энэхүү гэрээг Улаанбаатар хотод 2 хувь үйлдэж, тал тус бүр 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.
- 10.2 Холбогдох хууль тогтоомжинд заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 10.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.4 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, улс орныг хамарсан эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.
- 10.5 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.
- 10.6 Гэрээнд гарын үсэг зурсан этгээдүүд нь талуудыг бүрэн төлөөлөх эрх бүхий этгээдүүд гэж үзэх бөгөөд үүнтэй холбогдон гарах эрсдэлийг талууд тус тусдаа хариуцна.

Гэрээ байгуулсан:

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

МОНГОЛ КОНТЕНТ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЭРХ ЭЗЭМШИГЧ:

.....

...../ /

Утас: 976 -75553131

Утас:

И-мэйл: contact@mongolcontent.mn

И-мэйл:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Марс төв

Хаяг: